

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны... дугаар
сарын -ний... өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2.г дэх дэд заалт, 11 дүгээр зүйлийн 11.8, 11.9, 11.10 дахь хэсгийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Экспортод бүтээгдэхүүн гаргасан “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээлийн хүүгийн татаас олгох, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлого, зохицуулалтын газар /Я.Эрдэнэсайхан/, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /Б.Батцэцэг/ нарт тус тус үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

Ч.ХҮРЭЛБААТАР

ТӨСӨЛ
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Сангийн сайдын 2020 оны дугаар сарын-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

**ЭКСПОРТОД БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАСАН ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧИД ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛИЙН
ХҮҮГИЙН ТАТААС ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8, 11.10 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.2 дахь заалтыг хэрэгжүүлэн экспортод гаргаж буй бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор экспортод бүтээгдэхүүнээ гаргасан “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /цаашид “Сан” гэх/-гаас зээлийн хүүгийн татаас олгох, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Зээлийн хүүгийн татаасын дэмжлэгт хамрагдахаар хүсэлт гаргасан үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан байгууллагад “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлж, тодорхойлолт авсан аж ахуйн нэгж байх ба экспортод гаргасан бүтээгдэхүүн, үйлчилгээний гаалийн мэдүүлгээ баталгаажуулсан байна.

1.3 Санд зээлийн хүүгийн татаас авах хүсэлт ирүүлсэн “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн хүсэлтийг Сан хүлээн авч, шийдвэрлэнэ.

1.4 Дараах тохиолдолд экспортлогчийн хүсэлтийг хүлээн авахгүй.

1.4.1. Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.11 дэх хэсэгт заасан;

1.4.2. Засгийн газрын тусгай сангууд, Зээлийн батлан даалтын сан, Олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилттэй хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэлтэй;

1.4.3. Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;

1.4.4. Байгаль орчин ба эрүүл мэндэд хортой технологи, материал хэрэглэсэн, экологийн хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон.

Хоёр. Зээлийн эх үүсвэр, нөхцөл

2.1 Зээлийн хүүгийн татаасын эх үүсвэр нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2. Зээлийн хүүгийн татаасын эх үүсвэрийг Төрийн сан дахь Сангийн дансанд төвлөрүүлнэ.

2.3. Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид үзүүлэх зээлийн хүүгийн татаасын хэмжээ нь сүүлийн жилийн борлуулалтын орлогоос хамааруулан дараахь хязгаартай байна:

№	Экспортын хэмжээ	Зээлийн хүүд үзүүлэх татаасын хэмжээ
1.	Борлуулалтын орлогын 50-с дээш %	5%
2.	Борлуулалтын орлогын 40-49%	4%
3.	Борлуулалтын орлогын 30-29 %	3%
4.	Борлуулалтын орлогын 20-29%	2%
5.	Борлуулалтын орлогын 20-с доош %	1%

2.4. Сангаас зээлийн хүүгийн татаас олгох шийдвэрийг арилжааны банканд хүргүүлж, санхүүжилтийг олгосноор экспортлогчийн зээлийн хүүг гэрээнд заасны дагуу 12 сарын хугацаанд хөнгөлнө.

Гурав. Тавигдах шаардлага, бүрдүүлэх материал

3.1. Зээлийн хүүгийн татаасын дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэл эрхлэгч нь дараах шаардлага хангасан байна.

3.1.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу “Дунд” ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч байх;

3.1.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ экспортолсон байх;

3.1.3. Арилжааны банкны бизнесийн зээлтэй байх;

3.2. Зээлийн хүүгийн татаасын дэмжлэгт хамрагдах үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь дараах материалыг ирүүлсэн байна.

3.2.1. Зээлийн хүүгийн татаасын дэмжлэгт хамрагдах тухай хүсэлтээ албан бичээр гаргах;

3.2.2. Захирлын иргэний үнэмлэхийн хуулбар;

3.2.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

3.2.4. Экспортод гаргадаг бүтээгдэхүүний танилцуулга, үйлдвэрлэлд ашиглагдаж буй түүхий эдийн орц, технологийн үе шатанд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь;

3.2.5. Арилжааны банкны бизнесийн зээлийн гэрээний хуулбар, эргэн төлөлтийн хуваарийн хуулбар;

3.2.6. Сүүлийн жилийн санхүүгийн баталгаажсан тайлан;

3.2.7. Сүүлийн жилд экспортод гаргасан бүтээгдэхүүний гаалийн мэдүүлгийн баримт;

3.2.8. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлсэн тухайн жилийн тодорхойлолт;

3.2.9. Нийгмийн даатгалд хамруулсан ажилтны тоо, төлж байгаа шимтгэлийн хэмжээ болон нийгмийн даатгалын байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;

3.2.10. Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт;

3.2.11. Төлсөн татварын хэмжээ болон татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх харьяа татварын албаны тодорхойлолт.

Дөрөв. Хүсэлтийг хүлээн авах, зарлах

4.1. Улсын төсвийн санхүүжилт хуваарилагдсан тохиолдолд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүсэлтийг хүлээн авна.

4.2. Сан нь улсын хэмжээнд хүсэлт хүлээн авах зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

4.3. Сан нь хүсэлт хүлээн авах хугацаа зарлагдахаас бусад үед хүсэлтийг хүлээн авахгүй.

Тав. Гэрээ байгуулах, санхүүжилт олгох

5.1. Зээлийн хүүгийн татаасыг арилжааны банкинд олгохдоо дараах байдлаар санхүүжүүлнэ.

5.1.1. Сан хүсэлтийг хүлээн авч, шаардлага хангасан материалыг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

5.1.2 Сан нь “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч болон харилцагч арилжааны банктэй гэрээ байгуулна. (Гэрээний загварыг жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан батална)

5.1.3 Сан нь зээлийн хүүгийн татаасын дэмжлэгийг арилжааны банкны холбогдох данс руу гэрээнд заасан хугацаанд төгрөгөөр олгоно.

5.1.4. “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн банктэй байгуулсан зээлийн гэрээтэй холбогдож гарах аливаа асуудлыг Сан хариуцахгүй.

Зургаа. Ил тод байдал, хяналт тавих

6.1. Шаардлага хангаагүй шалтгаан, тайлбарын хамт “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид тухай бүр мэдэгдэнэ.

6.2. Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан Сангийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

6.3. Сангийн ажлын алба зээлийн хүүгийн татаасын дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжийн холбогдох мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлнө.

6.4. Сан нь зээлийн хүүгийн татаасын дэмжлэгт хамрагдсан “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн экспортолсон бүтээгдэхүүний тайланг улирал бүр гаргуулан авч Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна;

6.5. Сан нь зээлийн хүүгийн татаасын дэмжлэгт хамрагдсан “Дунд” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн банкнаас авсан зээлийн эх үүсвэрээ экспортод чиглэсэн арга хэмжээнд зарцуулж буй эсэхэд хяналт тавина;

6.6. Сан нь зээлийн хүүгийн татаастай холбогдсон үйл ажиллагаа, орлого, зарлагын гүйцэтгэлд жил бүр хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод аудитын хороогоор хэлэлцүүлнэ.

6.7. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй буюу энэ журамд заасныг зөрчиж зээлийн хүүгийн татаас олгосон, сангийн хөрөнгөд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт, шалгалтаар тогтоогдсон бол холбогдох албан тушаалтанд зохих хууль журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.